



00-аанг түмэн хэвлэл  
оны 03 дугаар сарын 05  
№09 /630/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

302

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

332

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

333

## Концессын тухай

**Зарим хүмүүсийг шүүгч,  
Ерөнхий шүүгчийн албан  
тушаалд томилох тухай**

**Газрын тосны зарим  
бүтээгдэхүүний онцгой  
албан татварын тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |     |   |     |
|-----|---|-----|
| 80. | Концессын тухай тухай   | 302 |
| 81. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай        | 330 |
| 82. | Мянганы сорилтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг соёрхон батлах тухай | 331 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |     |   |            |     |
|-----|---|------------|-----|
| 83. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай   | Дугаар 174 | 331 |
| 84. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай                        | Дугаар 175 | 332 |
| 85. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилж тухай                            | Дугаар 176 | 332 |
| 86. | Зарим хүмүүсийг аймаг, аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилж тухай | Дугаар 177 | 333 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |     |   |            |     |
|-----|---|------------|-----|
| 87. | Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай                             | Дугаар 365 | 333 |
| 88. | Зарим аймагт өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 367 | 334 |



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 01 дүгээр  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОНЦЕССЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Концессын тухай хууль тогтоомж

2.1.Концессын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Монгол Улсын Засгийн газрын тухай<sup>3</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай<sup>4</sup>, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль<sup>5</sup> болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний звалтыг дагаж мөрдөнө.

2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тус тус заасан төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчийг концессын гэрээгээр эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцаа энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Иргэний хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Монгол Улсын Засгийн газрын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

2.4.Энэ хуульд заасан журмын дагуу эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь шилжсэн, шинээр бий болсон эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид авах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай<sup>8</sup> хуулиар тус тус зохицуулна.

2.5.Концессын зүйл нь газрын үндсэн бүрдэл хэсэг бол тухайн газрыг Газрын тухай<sup>1</sup>, Газрын хэвлийн тухай<sup>6</sup>, Газрын төлбөрийн тухай<sup>9</sup> хуульд заасан журмын дагуу эзэмшүүлж, ашиглуулна.

### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."концесс" гэж төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дад бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрхийг;

3.1.2."концессын зүйл" гэж энэ хуулийн 10.1, 10.2-т заасан жагсаалтад орсон зүйлийг;

3.1.3."концессын гэрээ" гэж концессыг хэрэгжүүлэхээр эрх бүхий этгээд, концесс эзэмшигч нарын хооронд бичгээр байгуулсан гэрээг;

3.1.4."концесс эзэмшигч" гэж энэ хуульд заасан журмын дагуу концесс авсан Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлийг;

3.1.5."концессыг санхүүжүүлэгч" гэж концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд зориулан эзэл олгох, баталгаа гаргах зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн этгээдийг;

3.1.6."зохицуулах байгууллага" гэж концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ

<sup>8</sup>Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>1</sup>Газрын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Газрын хэвлийн тухай хууль- ХТГЖ –ийн 1988 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>9</sup>Газрын төлбөрийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

тариф тогтоох, концессын зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг.

3.1.7. "эрх бүхий этгээд" гэж төрийн өмчийн концессын зүйлийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг, орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд аймаг, нийслэлийн Засаг даргыг.

#### **4 дүгээр зүйл. Концессын төрөл**

4.1. Концесс нь дараахь төрөлтэй байж болно:

4.1.1. "Барих-ашиглах-шилжүүлэх" – концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;

4.1.2. "Барих-шилжүүлэх" – концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;

4.1.3. "Барих - өмчлөх - ашиглах" - концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр өмчлөх, ашиглах эрх эдэлж, үүрэг хүлээх;

4.1.4. "Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх" – концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан хугацаанд өмчлөн ашиглаж, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;

4.1.5. "Барих-түрээслэх-шилжүүлэх" – концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдэд санхүүгийн түрээсээр эзэмшүүлэх, түрээсийн хугацаа дуусгавар болоход төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх;

4.1.6. "Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах" – концесс эзэмшигч концессын зүйлийн зураг төслийг боловсруулан өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж гэрээнд заасан

хугацаанд ашиглан, хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх.

4.1.7."Шинэчлэн сайжруулах - ашиглах - шилжүүлэх" - концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр шинэчлэн сайжруулж гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг шинэчлэн сайжруулсан зүйлийн хамт төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх.

4.2.Тухайн концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний онцлогоос шалтгаалан энэ хуулийн 4.1-д зааснаас бусад концессын төрөл байж болно.

### **5 дугаар зүйл.Концессын зүйлтэй холбоотой өмчийн эрх**

5.1.Концессын зүйл болон түүний эд анги, тоног төхөөрөмжийн өмчлөлийн асуудлыг концессын гэрээгээр зохицуулах бөгөөд тэдгээрийг дараахь байдлаар ангилан гэрээнд тусгаж болно.

5.1.1.концессын гэрээний дагуу төрийн болон орон нутгийн өмчлөлд, эсхүл бусад этгээдэд шилжүүлэх эд хөрөнгө;

5.1.2.концесс эзэмшигчээс төр болон орон нутаг өмчлөлдөө худалдан авч болох эд хөрөнгө;

5.1.3.концессын гэрээг дуусгавар болсны дараа концесс эзэмшигч өөртөө үлдээх болон захиран зарцуулж болох эд хөрөнгө.

5.2.Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын гэрээгээр шинэчлэн сайжруулах концессын зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарна.

5.3.Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын зүйлийг ашиглах явцад бий болсон биет эд хөрөнгө болон оюуны үнэт зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарна.

5.4.Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын зүйлийг эзэмших, ашиглах хугацаанд олсон энэ хуулийн 5.3-т зааснаас бусад орлого, ирээдүйд бий болох ашиг нь концесс эзэмшигчийн өмчид хамаарна.

5.5.Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концесс эзэмшигчид ашиглуулахаар шилжүүлсэн концессын зүйл, газар ба бусад эд хөрөнгө нь гэрээнд заасан зориулалтаар цавшид ашиглагдах боломжгүй, эсхүл шаардлагагүй болсноос бусад тохиолдолд эрх бүхий этгээд болон төрийн



бусад байгууллага, албан тушаалтан концессын гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг буцаан авах, эсхүл захиран зарцуулах шийдвэр гаргахыг хориглоно.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
КОНЦЕССЫН ТАЛААР ТӨРИЙН, НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ  
БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

**6 дугаар зүйл. Төрийн байгууллагын бүрэн эрх**

**6.1. Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

6.1.1. төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах;

6.1.2. концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг энэ хуулийн 6.2-т заасан байгууллагад олгох;

6.1.3. концессын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд жил бүр мэдээлэх;

6.1.4. хууль тогтоомжид заасан бусад.

6.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.2.1. төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын талаархи саналыг бэлтгэж Засгийн газарт оруулах;

6.2.2. концессын зүйлийн талаар судалгаа хийх, санал боловсруулах;

6.2.3. концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх;

6.2.4. концесс олгох, хэрэгжүүлэх талаар холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6.2.5. концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.2.6. улсын хэмжээнд концессын талаархи нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

6.2.7.хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон тохиолдолд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох;

6.2.8.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалтын баримт бичгийг төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, уралдаант шалгаруулалтыг зарлах, түүнийг зохион байгуулж дүгнэх;

6.2.9.концессын гэрээ болон түүнтэй холбоотой бусад гэрээ, тухайлбал, концесс эзэмшигч санхүүжилт олохтой холбогдсон гэрээг концесс эзэмшигч болон бусад этгээдтэй байгуулах;

6.2.10 хууль тогтоомжид заасан бусад.

6.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь концессын талаар орон нутгийн холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

#### **7 дугаар зүйл.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх**

7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд концессын зүйлийн жагсаалтын талаархи саналыг бэлтгэж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах болон энэ хуулийн 6.2.2-6.2.6, 6.2.8-6.2.10-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

#### **8 дугаар зүйл.Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хориглох зүйл**

8.1.Төрийн, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

8.1.1.концессын зүйлийн жагсаалтад ороогүй төрийн, эсхүл орон нутгийн өмчийн зүйлийг концессоор олгох;

8.1.2.концессын гэрээний хугацаанд концессын зүйлийг хувьчлах шийдвэр гаргах;

8.1.3.хууль тогтоомж, гэрээнд зааснаас бусад тохиолдолд





концесс эзэмшигчийн аж ахуйн үйл ажиллагаанд оролцох;

8.1.4 хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалтад оролцогч, концесс эзэмшигчийн худалдаа, аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах нууцыг задруулах.

8.2.Төрийн, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь концесс эзэмшигчид шилжүүлсэн концессын зүйлийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх, шинэчлэн сайжруулах эрх буюу үүрэг хүлээхгүй бөгөөд концесс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр концессын зүйлтэй холбогдсон зээлийн гэрээ, эсхүл барьцааны гэрээ байгуулахыг хориглоно.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

#### 9 дүгээр зүйл.Концессын зүйлийн жагсаалт боловсруулах

9.1.Тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан концессын зүйлийн талаархи саналаа, зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан саналыг төрийн захиргааны төв байгууллагууд хамтран гаргаж болно.

9.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сайхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын талаархи саналаа эцэслэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.

9.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаархи энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа, зардал, ашгийн тооцооны хамт тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

9.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 9.4-т заасны дагуу саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхээс өмнө тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулалтын болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.

9.6.Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх аргачлалыг



терийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

### **10 дугаар зүйл.Концессын зүйлийн жагсаалт батлах**

10.1.Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.

10.2.Орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

10.3.Концессын зүйлийн жагсаалтад дараахь зүйлийг тусгана.

10.3.1.концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ,

10.3.2.төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх,

10.3.3.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ КОНЦЕСС ОЛГОХ**

### **11 дүгээр зүйл.Төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт**

11.1.Энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд концессыг төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт /цаашид "уралдаант шалгаруулалт" гэх/ -ын аргаар олгоно.

11.2.Уралдаант шалгаруулалтыг эрх бүхий этгээд зохион байгуулж, дүгнэх бөгөөд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.2.1.уралдаант шалгаруулалтын баримт бичиг болон түүнийг явуулах үе шат, үнэлэх журмыг боловсруулж, батлах;

11.2.2.уралдаант шалгаруулалтыг товлон зарлах;

11.2.3.төслийн саналыг хүлээн авч, үнэлж, оролцогчтой хэлэлцээр хийж, уралдаант шалгаруулалтыг дүгнэх;

11.2.4.энэ хуулийн 11.2.3-т заасан дүгнэлтээ Засгийн газар, эсхүл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж,



шийдвэрлүүлэх.

11.3.Уралдаант шалгаруулалтыг дараахь үе шаттайгаар зохион байгуулна:

11.3.1.уралдаант шалгаруулалтыг зэрлэх;

11.3.2.уралдаант шалгаруулалтад оролцох саналыг хүлээн авах;

11.3.3.уралдаант шалгаруулалтад оролцох саналыг үнэлж уралдаант шалгаруулалтад оролцогчийг /цаашид "оролцогч" гэх/ сонгох ;

11.3.4.оролцогчдод уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгох;

11.3.5.шаардлагатай бол оролцогч эрх бүхий этгээдтэй уулзалт зохион байгуулах, холбогдох мэдээлэл, баримт бичигтэй танилцах;

11.3.6.оролцогч төслийн саналаа боловсруулж ирүүлэх;

11.3.7.төслийн саналыг зохих журмын дагуу хүлээн авах;

11.3.8.төслийн саналыг үнэлж, шалгарсан оролцогчдын жагсаалтыг гаргах;

11.3.9.шалгарсан оролцогчидтой гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийх;

11.3.10.уралдаант шалгаруулалтын дүнг холбогдох байгууллагад хүргүүлж, зохих шийдвэр гаргуулах.

11.4.Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журмыг Засгийн газар батална.

11.5.Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахдаа нийт оролцогч харилцан эрх тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлж, тэднийг мэдээллээр ижил түвшинд хангах, ижил шаардлага тавих, уралдаант шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод байх зарчмыг баримтална.

11.6.Эрх бүхий этгээдээс шаардсан аливаа мэдээллийг оролцогч гаргаж өгөх үүрэгтэй.

11.7.Барааны тэмдэг, нэр, хэлбэр, төрөл, гарал үүсэл, газар зүйн

байршил, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг уралдаант шалгаруулалтын баримт бичигт урьдчилан заахыг хориглоно.

## **12 дугаар зүйл. Уралдаант шалгаруулалтыг зарлах**

12.1. Уралдаант шалгаруулалтын зар мэдээнд дараахь мэдээллийг тусгана:

12.1.1. концессын зүйлийн тодорхойлолт;

12.1.2. шаардлагатай бол гэрээний ерөнхий нөхцөл,

12.1.3. оролцогчид тавих ерөнхий шаардлага;

12.1.4. уралдаант шалгаруулалтад хуулийн этгээдийн нэгдэл оролцож болох эсэх;

12.1.5. уралдаант шалгаруулалтад зөвхөн хязгаарлагдмал тооны этгээдийг оруулах эсэх;

12.1.6. уралдаант шалгаруулалтын ялагч концессыг хэрэгжүүлэх хуулийн этгээд байгуулах эсэх;

12.1.7. уралдаант шалгаруулалт явуулах үе шат, журам;

12.1.8. уралдаант шалгаруулалтад оролцох хүсэлт хүлээн авах хаяг, хэлбэр, хугацаа;

12.1.9. эрх бүхий этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

12.2. Уралдаант шалгаруулалтын зар мэдээг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэхээс гадна, шаардлагатай бол олон улсад өргөн хэрэглэгддэг хэлээр гардаг тухайн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

12.3. Уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн этгээд саналыг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө урьд нь өгсөн саналаа буцаан авах, эсхүл дахин санал ирүүлэх эрхтэй.

12.4. Уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хугацаа нь түүнийг нийтэд зарласнаас хойш хоёр сараас доошгүй байна.



12.5.Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр нийтэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

### **13 дугаар зүйл.Оролцогчийг сонгон шалгаруулах**

13.1.Энэ хуулийн 12.1.3-т заасан ерөнхий шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдэл уралдаант шалгаруулалтад оролцохоор энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн дагуу бүрдүүлсэн саналаа битүүмжлэн эрх бүхий этгээдэд ирүүлэх эрхтэй.

13.2.Эрх бүхий этгээд нь энэ хуулийн 13.1-д заасан саналыг ирүүлсэн хугацааны дарааллаар бүртгэн хүлээн авна.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан саналыг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлэн оролцогчийг сонгон шалгаруулна:

13.3.1.санхүүгийн чадавхи;

13.3.2.удирдлага, мэргэжлийн боловсон хүчин, техник, технологийн чадвар, туршлага;

13.3.3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай<sup>10</sup> хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангасан эсэх;

13.3.4.энэ хуулийн 12.1.3-т заасан шаардлагыг хангасан эсэх;

13.3.5.эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлт.

13.4.Уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн хуулийн этгээдийн нэгдлийг үнэлэхдээ дараахь зарчмыг баримтална:

13.4.1.энэ хуульд заасан шалгуур үзүүлэлт нь зөвхөн хуулийн этгээдийн нэгдэлд бүхэлд нь хамаарах;

13.4.2.хуулийн этгээдийн нэгдлийн гишүүн нь нэг уралдаант шалгаруулалтын өвцэд нэг хуулийн этгээдийн нэгдлийн гишүүн байх;

13.4.3.уралдаант шалгаруулалтын зар мэдээнд өөрөөр

<sup>10</sup>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

заагаагүй бол хуулийн этгээд нь нэг уралдаант шалгаруулалтад хуулийн этгээдийн нэгдлийн гишүүнээр оролцсон бол тухайн шалгаруулалтад бие даан оролцохгүй байх.

13.5.Эрх бүхий этгээд концессын зүйлийн онцлогоос шалтгаалан оролцогчдын жагсаалтыг тодорхой тоогоор хязгаарлах, түүнчлэн оролцогч энэ хуулийн 13.3, 13.4-т заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг уралдаант шалгаруулалтын аль ч шатанд дахин шалгаж болно.

13.6.Эрх бүхий этгээд энэ хуулийн 13.3, 13.4-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан оролцогчдоор хязгаарлан төслийн саналаа ирүүлэх эрх бүхий оролцогчдын жагсаалтыг гарган тэдгээрт мэдэгдэж, уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгох ажлыг зохион байгуулна.

13.7.Уралдаант шалгаруулалтын баримт бичигт дараахь зүйлийг тусгана:

13.7.1.төслийн талаархи ерөнхий мэдээлэл;

13.7.2.шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах концессын зүйлийн тоо хэмжээ, хүчин чадал зэрэг нарийвчилсан үзүүлэлт;

13.7.3.концессын зүйлийг эзэмших, ашиглах эрхийн хязгаар, түүнчлэн гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний тоо хэмжээ, хүчин чадал зэрэг нарийвчилсан үзүүлэлт;

13.7.4.концессын зүйлийг ашиглах, эзэмшихтэй холбогдсон үнэ, тариф, тусгай зөвшөөрөл болон холбогдох бусад мэдээлэл;

13.7.5.байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын тусгай шаардлага;

13.7.6.ерөнхий нөхцөлийг тусгасан гэрээний төсөл, нэмэлт гэрээ байх эсэх, байх бол тэдгээрийн талаархи мэдээлэл, гэрээ байгуулах талтай үл тохиролцох нөхцөл;

13.7.7.концессын зүйлийг ашигласны төлөө төлбөр төлөх эсэх, төлөх бол түүний хэмжээ, төлөх хэлбэр;

13.7.8.төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэх, үзүүлэх бол түүний хэлбэр, хэмжээ;

13.7.9.төслийн саналыг хүлээн авах, задлах, үнэлэх журам, шалгуур үзүүлэлт.

13.7.10 дэнчингийн хэмжээ, түүнийг байршуулах данс, хугацаа, нөхцөл;

13.7.11 төслийн санал хүлээн авах хаяг, хэлбэр, хугацаа.

13.8. Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулж болох бөгөөд ийнхүү өөрчлөлт оруулсан бол түүнийг оролцогчид төслийн саналаа гаргах боломжит хугацаанд мэдэгдэх буюу, эсхүл төслийн саналаа ирүүлэх хугацааг нь сунгаж болно.

13.9. Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан нийт оролцогчид мэдээлэл өгөх зорилгоор уулзалт зохион байгуулж болно.

13.10. Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын баримт бичгийг батлах, төслийн саналыг үнэлэх болон энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан томилон ажиллуулж болно.

#### **14 дүгээр зүйл. Төслийн санал ирүүлэх, түүнийг үнэлэх**

14.1. Энэ хуулийн 13.6-д заасан оролцогч уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу боловсруулсан төслийн саналаа техник, эдийн засгийн үндэслэлийн хамт битүүмжлэн ирүүлнэ.

14.2. Эрх бүхий этгээд нь төслийн саналыг ирүүлсэн хугацаа, хэлбэрийг нь тэмдэглэн хүлээн авч, уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу задлан, үнэлэх ажлыг зохион байгуулна.

14.3. Төслийн саналыг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

14.3.1. техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ;

14.3.2. үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж;

14.3.3. концессын гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ;

14.3.4. концессын гэрээний хугацаанд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийн тухайн үеийн нийт хэмжээ, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнэ;

14.3.5. зураг төсөл, барилгын ажлын өртөг, урсгал зардал, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнэ;

14.3.6. төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний хэлбэр, хэмжээ;

14.3.7. санхүүжилтийн төлөвлөгөө;

14.3.8. улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө;

14.3.9. байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангаж байгаа эсэх;

14.3.10. эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлт.

14.4. Эрх бүхий этгээд төслийн саналыг энэ хуулийн 14.3-т заасны дагуу харьцуулан үнэлж хамгийн сайн нөхцөл санал болгосноос нь эхлэн дараалуулсан жагсаалт гаргана.

14.5. Төслийн саналаа ирүүлэх, түүнийг үнэлэх журам нь нийтэд нээлттэй байх бөгөөд шаардлагатай бол түүнийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

### **15 дугаар зүйл. Оролцогчтой хэлэлцээр хийх, уралдаант шалгаруулалтыг дүгнэх**

15.1. Эрх бүхий этгээд оролцогчтой концессын болон холбогдох бусад гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийнэ.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасан хэлэлцээр хийхэд дараахь журмыг баримтална.

15.2.1. эрх бүхий этгээд нь хамгийн сайн нөхцөл санал болгосон оролцогчтой эхэлж хэлэлцээр хийх боловч тухайн хэлэлцээрийг дуусгалгүйгээр орхиж, дараагийн оролцогчтой хэлэлцээр хийх эрхтэй байх;

15.2.2. хэлэлцээр хийхдээ энэ хуулийн 14.4-т заасан жагсаалтын дарааллыг баримтлах.

15.3. Эрх бүхий этгээд хэлэлцээрийн үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохирсон нэг оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлт гарган ажлын таван өдөрт багтаан Засгийн газарт, эсхүл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.





## **16 дугаар зүйл.Төслийн санал гаргах ажиллагааг хоёр шаттай явуулах**

16.1.Концессын зүйлийн төрөл, салбарын онцлогоос шалтгаалан техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтийг уралдаант шалгаруулалтын баримт бичигт нарийвчлан тусгах боломжгүй гэж эрх бүхий этгээд үзвэл төслийн санал гаргах ажиллагааг хоёр шаттай явуулж болно.

16.2.Төслийн санал гаргах ажиллагааг хоёр шаттай явуулахдаа энэ хуулийн 13.7-д заасан асуудлаар тусгайлан санал ирүүлэх хүсэлтийг оролцогчид тавина.

16.3.Эрх бүхий этгээд оролцогчоос ирүүлсэн энэ хуулийн 16.2-т заасан саналыг харгалзан уралдаант шалгаруулалтын баримт бичгийг эцэслэн боловсруулна.

16.4.Эрх бүхий этгээд энэ хуулийн 16.2-т заасан саналыг тодруулах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор оролцогчтой уулзалт зохион байгуулж болно.

16.5.Оролцогч энэ хуулийн 16.3-т заасан баримт бичгийн хүрээнд төслийн саналаа эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

16.6.Эрх бүхий этгээд төслийн саналыг үнэлэх, хэлэлцээр хийх, дүгнэхдээ энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

## **17 дугаар зүйл.Шууд гэрээ байгуулах**

17.1.Дор дурдсан тохиолдолд шууд гэрээ байгуулах аргаар концессыг олгож болно:

17.1.1.уралдаант шалгаруулалт явуулах нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэж үзсэн;

17.1.2.концессыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай оюуны үнэт зүйлтэй холбоотой эрх нэг буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн өмчлөлд байгаа;

17.1.3.уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй, эсхүл шаардлагад нийцсэн санал ирээгүй бөгөөд уралдаант шалгаруулалт дахин зарласан ч шаардлагатай хугацаанд санал ирэх магадлал бага гэж эрх бүхий этгээд үзсэн;

17.1.4.концессын зүйлийг энэ хуулийн 28 дугаар зүйлд



заасны дагуу бусад этгээдэд шилжүүлсэн.

17.2. Шууд гэрээ байгуулах дүгнэлтийг эрх бүхий этгээд гаргаж Засгийн газар, эсхүл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

### **18 дугаар зүйл. Өөрийн санаачилгаар концессын гэрээ байгуулах санал ирүүлэх**

18.1. Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдэл нь өөрийн санаачилгаар концессын гэрээ байгуулах төслийн саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд ирүүлж болно.

18.2. Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд эрх бүхий этгээд нь энэ хуулийн 18.1-д заасан саналын талаар тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авч, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн уг саналыг концессын зүйлийн жагсаалтад оруулахыг дэмжих эсэхийг шийдвэрлэнэ.

18.3. Орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд эрх бүхий этгээд нь шийдвэр гаргахдаа энэ хуулийн 9.5-д заасан байгууллагын саналыг авсан байвал зохино.

18.4. Эрх бүхий этгээд энэ хуулийн 18.1-д заасан саналыг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан журмын дагуу концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгах, эсхүл дараа жилийн концессын зүйлийн жагсаалтад оруулах нь зүйтэй гэж үзвэл энэ талаар Засгийн газар, эсхүл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд саналаа хүргүүлнэ.

18.5. Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн зүйлийг концессын зүйлийн жагсаалтад оруулахаар шийдвэрлэвэл эрх бүхий этгээд энэ хуульд заасны дагуу уралдаант шалгаруулалт явуулна.

18.6. Энэ хуулийн 18.5-д заасан уралдаант шалгаруулалтад оролцох хүсэлтээ өөр оролцогч ирүүлээгүй бол эрх бүхий этгээд анх санаачилга гаргасан этгээдийг хамгийн сайн нөхцөл санал болгосон оролцогч гэж үзэж дүгнэлт гарган Засгийн газар, эсхүл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

18.7. Уралдаант шалгаруулалтад хэд хэдэн оролцогч оролцсон бол төслийн саналыг үнэлж, дүгнэлт гаргахдаа анх санаачилга гаргасан



этгээдэд давуу байдал олгох бөгөөд энэ талаар уралдаант шалгаруулалтын баримт бичигт урьдчилан завна.

### **19 дүгээр зүйл. Гэрээ байгуулах шийдвэр**

19.1. Энэ хуулийн 15.3, 17.2, 18.6, 18.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Засгийн газар гэрээ байгуулах зөвшөөрлийг эрх бүхий этгээдэд олгоно.

19.2. Концессын гэрээнд концесс эзэмшигчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт адлүүлэхээр заасан бол Засгийн газар уг асуудлыг Улсын Их Хурлаар батлуулна.

19.3. Энэ хуулийн 15.3, 17.2, 18.6, 18.7-д заасан дүгнэлтийг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэрээ байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгоно.

19.4. Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал концессын гэрээ байгуулахыг дэмжээгүй бол хэлэлцээрийг дахин хийх эсэх, эсхүл уралдаант шалгаруулалтыг дахин явуулах эсэх шийдвэрийн аль нэгийг гаргана.

19.5. Хэлэлцээр дахин хийх, уралдаант шалгаруулалтыг дахин явуулахад энэ хуульд заасан холбогдох журмыг баримтална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ КОНЦЕССЫН ГЭРЭЭ**

### **20 дугаар зүйл. Концессын гэрээний талууд**

20.1. Дараахь этгээд концессын гэрээний тал байна:

20.1.1. төрийн өмчийн зүйлийн концессын гэрээний хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн зүйлийн концессын гэрээний хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга,

20.1.2. уралдаант шалгаруулалтын ялагч,

20.1.3. шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэж байгаа бол энэ хуульд заасан шууд гэрээ байгуулах шаардлага хангасан этгээд.

### **21 дүгээр зүйл. Концессын гэрээний нөхцөл**

21.1. Хууль тогтоомж, гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын

гэрээг Монгол Улсын хуулийн дагуу байгуулж, тайлбарлах бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгасан байвал зохино:

21.1.1.концесс эзэмшигчид шилжүүлэх эд хөрөнгийн өмчлөл, концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх бүхий этгээд болон зохицуулах байгууллагын үүрэг хариуцлага;

21.1.2.концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хязгаар, концесс эзэмшигчийн эдлэх онцгой эрхийн хэмжээ;

21.1.3.концессын зүйлийг ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний төлөө концесс эзэмшигчийн төлбөр авах эрх, үнэ, төлбөр тогтоох, өөрчлөх аргачлал, түүнд хяналт тавих арга хэлбэр;

21.1.4.концесс эзэмшигчийн хувьцааны хяналтын багцыг шилжүүлэх, ийнхүү шилжүүлэхэд эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг авах нөхцөл;

21.1.5.концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, эсхүл үзүүлэх үйлчилгээний төлөө эрх бүхий этгээд төлбөр төлөхөөр бол түүний хэмжээ;

21.1.6.концесс эзэмшигчийн санхүүжилт олох, барьцааны эрх үүсгэх эсэх;

21.1.7.төрөөс концессын гэрээг хэрэгжүүлэхэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

21.1.8.концесс эзэмшигчид концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, газар буюу газар ашиглах эрх олж авахад дэмжлэг үзүүлэх талаар зохицуулах байгууллагын эрх, үүрэг;

21.1.9.газар, түүний хэвлийг эзэмших, ашиглахтай холбоотойгоор талуудын хүлээх эрх, үүрэг;

21.1.10.гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний тасралтгүй байдал, чанарын шаардлагыг хангах, гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээг өөрчлөх концесс эзэмшигчийн эрх;

21.1.11.үйлчилгээг нэг ангиллын бүх үйлчлүүлэгчид ижил нөхцөлөөр үзүүлэх концесс эзэмшигчийн үүрэг;

21.1.12.концессыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын



хууль тогтоомжид заасны дагуу хуулийн этгээд байгуулах бол түүний өөрийн хөрөнгийн доод хэмжээ, хуулийн этгээдэд тавих шаардлага;

21.1.13. тухайн концессыг хэрэгжүүлэхтэй шууд холбогдсон хууль тогтоомжид өөрчлөлт орсноор концесс эзэмшигчийн зардал нэмэгдсэн, орлого багассан тохиолдолд концесс эзэмшигчийн нөхөх олговор авах эрх;

21.1.14. эрх бүхий этгээдээс концессын зүйлийг түр шилжүүлэн авах нөхцөл байдал;

21.1.15. концесс эзэмшигчийг өөрчлөх нөхцөл;

21.1.16. концессын гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө концессын зүйлийг эзэмших, ашиглах, түүнчлэн түүнийг ашиглан ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдон үүссэн өр төлбөр, авлага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын, эсхүл төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хүлээсэн үүрэг, хариуцлага, тэдгээрийг шийдвэрлэх журам;

21.1.17. концесс эзэмшигчээс тайлан, мэдээ гаргаж өгөх үүрэг;

21.1.18. өндөр өртөгтэй, эсхүл сонирхлын зөрчилтэй хэлэлцээр хийх, түүнд төрийн эрх бүхий байгууллагаас хяналт тавих журам;

21.1.19. концессын гэрээ дуусгавар болж концессын зүйлийг шилжүүлсний дараа уг зүйлийн чанарын баталгааны талаар концесс эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлага;

21.1.20. концессын зүйлийг шалгах, турших, хүлээж авах, зөвшөөрөл олгох, концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, концессын зүйлийг шилжүүлснээр түүнийг ашиглах технологийг шилжүүлэх, ажилтныг сургах журам;

21.1.21. шаардлагатай бол концессын зүйлийг шилжүүлсний дараа түүнийг ашиглахтай холбогдуулан концесс эзэмшигчээс үргэлжлүүлэн үзүүлэх үйлчилгээ;

21.1.22. концессын зүйлийг гэрээнд заасан этгээдэд, эсхүл шинэ концесс эзэмшигчид шилжүүлсэнтэй холбогдуулан төлбөр төлөхөөр бол түүний хэмжээ;

21.1.23. концессын гэрээний хугацаа, түүнийг сунгах,



гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, концессын гэрээ ба холбогдох бусад гэрээний хоорондын харилцаа гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, концессын зүйлийг хүлээлгэн өгөх ба шилжүүлэх арга хэмжээ, маргаан шийдвэрлэх журам,

21.1.24. талууд харилцан тохиролцсон бусад.

## 22 дугаар зүйл. Концессын гэрээний хугацаа, түүнийг сунгах

22.1. Концессын гэрээний хугацааг тухайн салбарын онцлог, хөрөнгө сруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнийг нөхөх хугацаа, олох ашиг, концессын зүйлийн ашиглалтын хугацаа зэргийг харгалзан гэрээний талууд тохиролцоно.

22.2. Дор дурдсан тохиолдолд концессын гэрээний хугацааг эрх бүхий этгээд сунгана.

22.2.1. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;

22.2.2. төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;

22.2.3. эрх бүхий этгээдийн концессын гэрээнд тусгагдаагүй хүсэлт, шаардлага нь концесс эзэмшигчийн зардлыг өсгөхөд хүргэсэн бөгөөд концесс эзэмшигч гэрээний хугацааг сунгалгүйгээр тухайн зардлыг нөхөх боломжгүй болсон.

22.3. Концесс эзэмшигчид санхүүгийн үр дагавар үүсгэх, эсхүл нийтэд хэт өндөр үнэ тариф, төлбөр ногдуулахад хүргэх урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн үед концессын гэрээг эрх бүхий этгээд сунгаж болно.

## 23 дугаар зүйл. Концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

23.1. Гэрээний талууд харилцан тохиролцож концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

23.2. Концесс эзэмшигч дараахь тохиолдолд нөхөн төлбөр авахаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно:

23.2.1. санхүү, эдийн засгийн нөхцөл байдал

өөрчлөгдсөн;

23.2.2.хууль тогтоомж өөрчлөгдсөн.

23.3.Энэ хуулийн 23.2.1, 23.2.2-т заасан нөхцөл нь гэрээг байгуулсны дараа үүссэн бөгөөд ийм нөхцөл байдал бий болохыг урьдчилан мэдэх боломжгүй байсан, түүнчлэн уг нөхцөл байдлыг концесс эзэмшигч өөрөө даван гарах боломжгүй болсон тохиолдолд энэ хуулийн 23.2-т заасан саналыг гаргана.

23.4.Энэ хуулийн 23.2, 23.3-т заасны дагуу гэрээний нөхцөлийг өөрчлөх журмыг концессын гэрээнд заана.

#### **24 дүгээр зүйл.Концессын гэрээ дуусгавар болох, гэрээг цуцлах**

24.1.Дараахь тохиолдолд концессын гэрээ дуусгавар болно:

24.1.1.талууд харилцан тохиролцсон;

24.1.2.гэрээний хугацаа дууссан бөгөөд гэрээг сунгаагүй;

24.1.3.хууль, концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концесс эзэмшигч дамлуурсан буюу татан буугдсан;

24.1.4.энэ хууль болон концессын гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан.

24.2.Концессын гэрээг дараахь тохиолдолд эрх бүхий этгээдийн санаачилгаар цуцална:

24.2.1.концесс эзэмшигч нь уралдаант шалгаруулалтад оролцоходоо хууль зөрчсөн буюу хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон;

24.2.2.концесс эзэмшигч нь Монгол Улсын хууль тогтоомжийг удаа дараа буюу ноцтой зөрчсөнийг эрх бүхий байгууллага тогтоосон ;

24.2.3.концесс эзэмшигч концессын гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй нь гэрээнд зааснаар гэрээг цуцлах үндэслэл болсон;

24.2.4.үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн.



24.2.5.концессын гэрээнд зааснаас бусад тохиолдолд концесс эзэмшигчийн хувьцааны хяналтын багцыг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн;

24.2.6.хууль, концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концесс эзэмшигч дамлуурсан буюу татан буугдсан.

24.3.Концессын гэрээг дараахь тохиолдолд концесс эзэмшигчийн санаачилгаар цуцална:

24.3.1.эрх бүхий этгээд буюу зохицуулах байгууллага концессын гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй нь гэрээнд зааснаар гэрээг цуцлах үндэслэл болсон;

24.3.2.энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар гэрээний талууд харилцан тохиролцож чадаагүй нь гэрээнд зааснаар түүнийг цуцлах үндэслэл болсон;

24.3.3.хууль, концессын гэрээнд заасан бусад.

24.4.Концессын гэрээг цуцлахад талуудад олгох нөхөх олговрыг хэрхэн тооцохыг гэрээнд заах ба ингэхдээ концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэнэ, гарсан зардал, тухайн талд учирсан хохирол, үүний дотор шаардлагатай тохиолдолд олох боломжтой байсан ашгийг оруулна.

24.5.Энэ хууль болон концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээ дуусгавар болсноор концессын зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдох эрх төрийн өмчийн, эсхүл орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн холбогдох этгээдэд шилжинэ.

## **25 дугаар зүйл.Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих**

25.1.Концессын гэрээний хэрэгжилтэд дараахь этгээд хяналт тавина:

25.1.1.терийн өмчийн асуудал эрхэлсэн терийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллага;

25.1.2.тухайн концессын зүйлийг хариуцсан терийн захиргааны төв байгууллага;





25.1.3.хуульд заасан хяналт тавих эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
КОНЦЕСС ЭЗЭМШИГЧ, КОНЦЕССЫГ  
САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН БҮРЭН ЭРХ**

**26 дугаар зүйл.Концесс эзэмшигчийн эрх, үүрэг**

26.1.Концесс эзэмшигч нь дараахь нийтлэг эрхтэй:

26.1.1.гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнийхээ үнэ, төлбөрийн хэмжээг эрх бүхий этгээд зохицуулах байгууллагатай зөвшилцөн тогтоох, өөрчлөх, хураах;

26.1.2.шаардлагатай бол концессын гэрээтэй холбоотой бусад гэрээг зохицуулах байгууллага, эрх бүхий этгээдтэй хамтран байгуулах;

26.1.3.гэрээнд заасан хэлбэрээр санхүүжилт олж авах;

26.1.4.концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессыг хэрэгжүүлэх санхүүжилтийг олох зорилгоор өөрийн аливаа өмч, үүний дотор концессын зүйлтэй холбоотой өмч, эрхийг барьцаалах.

26.2.Энэ хуулийн 26.1.4-т заасан өмч, эрхэд дараахь зүйл орж болно:

26.2.1.концессын зүйлийг ашигласан, эсхүл үйлчилгээг нь хүртсэний төлөө төлөх бүх төрлийн төлбөр буюу ирээдүйд олох ашиг;

26.2.2.концесс эзэмшигч шинээр бий болгосон, шинэчлэн сайжруулсан концессын зүйл, эсхүл өөрийн худалдаж авсан эд хөрөнгө.

26.3.Концесс эзэмшигчийн хувьцаа эзэмшигч концессын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа барьцаалж болно.

26.4.Концесс эзэмшигч нь дараахь нийтлэг үүрэгтэй:

26.4.1.хууль тогтоомж болон концессын гэрээнд заасан үйл ажиллагаа эрхлэх;

26.4.2.гэрээний дагуу концессын төлбөр төлөхнөр бол

тогтоосон журмын дагуу төлөх;

26.4.3. гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний чанар, тоо, хэмжээг концессын гэрээнд заасан хэмжээнээс бууруулахгүй байх;

26.4.4. концессын зүйлийг концессын гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмших, ашиглах, засвар, үйлчилгээ хийх;

26.4.5. хууль тогтоомжоор ногдуулсан татвар, хураамж төлөх;

26.4.6. хуульд заасан бусад;

26.5. Концесс эзэмшигч нь концессын гэрээнд заасан тохиолдолд концессын зүйлийг гэнэтийн ослын даатгалд даатгуулах үүрэгтэй.

26.6. Концессын гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой ажил, үйлчилгээг туслан гүйцэтгүүлэгчээр гүйцэтгүүлж болох бөгөөд тухайн ажил, үйлчилгээний чанар, гүйцэтгэлийг концесс эзэмшигч хариуцна.

## **27 дугаар зүйл. Концесс эзэмшигчид хориглох зүйл**

27.1. Концесс эзэмшигчид дараахь зүйлийг хориглоно:

27.1.1. хууль болон концессын гэрээнд зааснаас бусад тохиолдолд эрх, үүргээ бусдад шилжүүлэх;

27.1.2. концессын зүйлийг бэлэглэх, арилжих, худалдах зэргээр бусдад шилжүүлэх, концессын үйл ажиллагааг санхүүжүүлэх, эсхүл концессын гэрээнд зааснаас бусад зорилгоор концессын зүйлийг барьцаалах;

27.1.3. концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын гэрээгээр гүйцэтгэхээр тохиролцсон ажил, үйлчилгээг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр тасалдуулах буюу зогсоох;

27.1.4. концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр хувьцааны хяналтын багцаа худалдах, барьцаалах зэргээр бусдад шилжүүлэх.

## **28 дугаар зүйл. Концессыг санхүүжүүлэгчийн эрх**

28.1. Концессыг санхүүжүүлэгч нь дараахь эрх эдэлнэ:

28.1.1. концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт

тавих;

28.1.2.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор концессын зүйл, түүний барилга байгууламжид нэвтрэх;

28.1.3.концесс эзэмшигчийн барьцаалсан эд хөрөнгө, эрхийг хууль тогтоомж болон холбогдох гэрээнд заасан журмын дагуу өөртөө шилжүүлэн авах;

28.1.4.концесс эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, концесс эзэмшигч дамлуурсан буюу татан буугдсан тохиолдолд концессын гэрээнд заасан журмын дагуу эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр концессын зүйлийг удирдах, өөр этгээдэд концессын зүйлийг шилжүүлэх саналыг эрх бүхий этгээдэд тавих;

28.1.5.концессын гэрээ болон санхүүжилттэй холбоотой бусад гэрээнд заасан эрх.

28.2.Эрх бүхий этгээд, концесс эзэмшигч, концессыг санхүүжүүлэгч нар харилцан тохиролцож гэрээ байгуулж болох ба түүнд дараахь зүйлийг тусгана:

28.2.1.концесс эзэмшигчийг өөрчлөх нөхцөл, журам;

28.2.2.концессыг эзэмшүүлэхээр шинээр санал болгосон этгээдээс эрх бүхий этгээд татгалзах үндэслэл;

28.2.3.концессын гэрээний дагуу шаардагдах нөхцөл, стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх концессыг санхүүжүүлэгчийн үүрэг;

28.2.4.концессын тухай хууль тогтоомжид заасан бусад.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ КОНЦЕССЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА**

### **29 дүгээр зүйл.Зөвшөөрөл, эрх олгох**

29.1.Уралдаант шалгаруулалтад оролцогч нь тухайн ажлыг гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хуульд заасан тусгай зөвшөөрөл аваагүй нь түүнийг уралдаант шалгаруулалтад оролцуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

29.2.Концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа

бол концесс эзэмшигчтэй концессын гэрээ байгуулснаас хойш холбогдох тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу нэн даруй олгоно.

29.3.Концессын зүйл нь газрын бүрдэл хэсэг бол концессын гэрээ байгуулснаас хойш тухайн газрыг ашиглах асуудлыг зохицуулах байгууллага зохих журмын дагуу нэн даруй шийдвэрлэх үүрэгтэй.

29.4.Концессыг хэрэгжүүлэхэд гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа газрыг дайран өнгөрөх, эсхүл уг газар дээр байгаа концессын зүйлтэй холбоотой аливаа барилга байгууламж, тоног төхөөрөмжид ажил, засвар, үйлчилгээ хийх шаардлагатай бол концесс олгохоос өмнө эрх бүхий этгээд буюу зохицуулах байгууллага уг асуудлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн байвал зохино.

### **30 дугаар зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг**

30.1.Төрөөс дараахь төрлийн санхүүгийн дэмжлэгийг концесс эзэмшигчид үзүүлж болно:

30.1.1.зээлийн баталгаа гаргах;

30.1.2.концессын санхүүжилтийн тодорхой хэсгийг гаргах;

30.1.3.холбогдох хуульд заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

30.1.4. даатгалд хамруулах;

30.1.5.концесс эзэмшигчийн концессын гэрээний дагуу олох орлогын хамгийн доод хэмжээнд баталгаа гаргах;

30.1.6.энэ хууль болон концессын гэрээнд заасан бол нөхөх олговор олгох;

30.1.7.бусад.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, нөхцөл, шаардлагыг концессын гэрээгээр тогтооно.

30.3.Талууд концессын гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийг бодит зардлаас бага байхаар тогтоосон бол зөрүүг улсын, эсхүл орон нутгийн төсвөөс нөхөн төлүүлэхээр харилцан тохиролцож болно.



30.4.Тухайн салбарын болон концессын зүйлийн онцлогийг харгалзан уг концесс эзэмшигч санхүүгийн хувьд алдагдалгүй ажиллах хүртэлх хугацаанд энэ хуулийн 30.3-т заасан нөхөн төлбөрийг олгоно.

### **31 дүгээр зүйл. Эрсдэлийг хуваах**

31.1.Концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концессыг хэрэгжүүлэхэд учирсан аж ахуйн үйл ажиллагааны эрсдэлийг концесс эзэмшигч бүрэн хариуцна.

31.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн эрсдэлийг хариуцах асуудлыг концессын гэрээгээр зохицуулна.

31.3.Концессын зүйлийг эзэмших, ашиглах хугацаанд өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирол, гэм хор, гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргийг концесс эзэмшигч бүрэн хариуцна.

### **32 дугаар зүйл. Концесс, концессын зүйлийг бусдад шилжүүлэх**

32.1.Хууль, концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол концесс эзэмшигчийн эрх, үүргийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

32.2.Эрх бүхий этгээдээс концесс эзэмшигчийн эрх, үүргийг бусдад шилжүүлэх зөвшөөрөл өгөх нөхцөл, шинэ концесс эзэмшигч эрх, үүргийг хүлээн авах, концессын гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техникийн болон санхүүгийн чадвартай гэдгийг нотлох журам зэргийг концессын гэрээнд тусгана.

32.3. Концесс эзэмшигч концессын гэрээг ноцтой буюу удаа дараа зөрчиж, эдгээр зөрчлийг арилгах шаардлагыг биелүүлээгүй бол эрх бүхий этгээд концессын зүйлээр гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээг саадгүй хангах зорилгоор концессын гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг өөрийн мэдэлд түр шилжүүлэн авч ажиллуулж болно.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **33 дугаар зүйл. Ил тод байдал**

33.1. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан жагсаалт, түүнд оруулсан



нэмэлт, өөрчлөлтийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээнэ.

33.2.Энэ хуулийн 11-15 дугаар зүйлд заасан уралдаант шалгаруулалтын болон шууд гэрээ байгуулах аргаар концессын гэрээ байгуулсан тухай бүрт концесс эзэмшигч, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээнийх нь талаар нийтэд мэдээлнэ.

33.3.Концессын гэрээний төрийн нууц болон концесс эзэмшигчийн худалдаа, технологийн нууцтай холбоотойгоос /байгууллагын нууцад хамаарахаас/ бусад хэсэг нийтэд нээлттэй байна.

33.4.Эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг, материалыг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгална.

#### **34 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх**

34.1.Концесс олгох ажиллагаатай холбогдсон гомдлыг тухайн ажиллагаа явагдсанаас хойш ажлын арван өдрийн дотор эрх бүхий этгээдэд гаргах бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

34.2.Концессын гэрээний талуудын хооронд үүссэн аливаа маргааныг гэрээгээр харилцан тохиролцсон аргаар шийдвэрлэнэ.

34.3.Концесс эзэмшигч, өөрийн хувьцаа эзэмшигч, концессыг санхүүжүүлэгч болон аж ахуйн үйл ажиллагааных нь хувьд хамтран ажиллаж байгаа бусад этгээдийн хооронд үүссэн маргааныг тэдгээрийн харилцан тохиролцсон аргаар шийдвэрлэнэ.

34.4.Концессын гэрээнд заасан үйл ажиллагаатай нь холбогдуулж концесс эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг хуульд заасан аргаар болон шүүхээр шийдвэрлэнэ.

#### **35 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

35.1.Концессын гэрээний талууд энэ хуулиар тогтоосон болон гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд завсны дагуу, хэрвээ гэрээнд ийнхүү заагаагүй бол Иргэний хуульд завснаар эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.

35.2.Энэ хуульд заасан дараахь журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн

хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг шүүгч, эсхүл улсын байцаагч ногдуулна.

35.2.1.уралдаант шалгаруулалт зохион байгуулахтай холбогдсон журмыг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтныг 200 000-250 000 төгрөгөөр торгох;

35.2.2.уралдаант шалгаруулалтын баримт бичгийг үнэлэх журам, энэ хуулийн 11.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 250 000-300 000 төгрөгөөр торгох;

35.2.3.энэ хуулийн 33 дугаар зүйлийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтыг 250 000-300 000 төгрөгөөр торгох.

35.3.Концессын хууль тогтоомжийг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай<sup>11</sup> хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулж болно.

### **36 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

36.1.Энэ хуулийг 2010 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 01 дүгээр  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

"6/концессын гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө."

**2 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

<sup>11</sup>Төрийн албаны тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаар нийлэгдэсэн.



"2.Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессоор эзэмшүүлэх, ашиглуулах, концессын гэрээний үндсэн дээр шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна."

**3 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх заалтын "1-4 дэх хэсэг" гэснийг "1-4, 6 дахь хэсэг" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Концессын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### МЯНГАНЫ СОРИЛТЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газар, Мянганы сорилтын Корпорациар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 174

Улаанбаатар  
хот

#### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:





Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн өөрөө хүсэлт гаргасан Лхамсүрэнгийн Ганчимэгийг Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2009 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 175

Улаанбаатар  
хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий  
шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2-т хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул Арвинбуянгийн Энхбаатарыг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Тогооборын Бямбажавыг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн, Лхүндэвийн Наранбаярыг Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2009 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар  
хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн  
албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Тогооборын



Бямбажавыг Дундговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, Арвинбуянгийн Энхбаатарыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

2009 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 177

Улаанбаатар  
хот

**Зарим хүмүүсийг аймаг, аймгийн захиргааны  
хэргийн шүүхийн шүүгчийн албан  
тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Лхүндэвийн Наранбаярыг Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Цэрэндоржийн Батмөнхийг Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2009 оны 12 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 365

Улаанбаатар  
хот

**Газрын тосны зарим бүтээгдэхүүний  
онцгой албан татварын тухай**

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дор дурдсанаар тогтоосугай



№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0.000	10.000	49.000
2	Ханх, Ульханмайхан	0.000	10.000	49.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	0.000	80.000	30.000

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 349 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 367

Улаанбаатар  
хот

**Зарим аймагт өвөлжилтийн байдал  
хүндэрсэнтэй холбогдуулан авах  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын нөөцөөс гаргаж аймгуудад олгох малын эм, биобэлгэмэлийн хуваарийг 1 дүгээр хавсралт, улсын нөөцийн салбар, цэгт нэмж байршуулах өвс, тэжээлийн хэмжээ болон түүнийг тээвэрлэх зардлын тооцоог 2 дугаар хавсралт, улсын нөөцөөс аймгуудад олгож, нөхөн бүрдүүлэх автомашин,



дизель станцын хуваарийг 3 дугаар хавсралт, улсын нөөцийн зарим салбараас өвөлжилт хүндэрсэн аймгийн малчдад худалдан борлуулах өвс, тэжээлийн хуваарийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай:

2.1. 2010 оны 1 дүгээр сард багтаан энэхүү тогтоолын дагуу улсын нөөцөөс гаргаж аймгуудад олгосон малын эм, биобэлдмэл болон автомашин, дизель станцыг нөхөн бүрдүүлэх, өвс, тэжээлийг улсын нөөцийн салбарт нэмж байршуулах ажлыг зохион байгуулах;

2.2. энэхүү тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан хуваарийн дагуу малчдад өвс, тэжээл худалдан борлуулах ажлыг зохион байгуулан борлуулалтын орлогоор нь 4500 тонн малын тэжээл худалдан авч 2009 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан нөхөн бүрдүүлэх, 4 дүгээр хавсралтад зааснаас бусад аймгийн улсын нөөцийн салбар, цэгт байршуулсан өвс, тэжээлийг нэмэлт хэрэгцээ, шаардлагыг харгалзан улсын хэмжээнд төлөвлөн малчдад худалдан борлуулах арга хэмжээ авах;

3. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй:

3.1. энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан малын эм, биобэлдмэлийг нөхөн бүрдүүлэхэд шаардагдах 21.0 (хорин нэгэн) сая төгрөг, 2 дугаар хавсралтад заасан улсын нөөцийн салбар, цэгт өвс, тэжээл нэмж байршуулах тээврийн зардалд шаардагдах 547.753.5 (таван зуун дөчин долоон сая долоон зуун тавин гурван мянга таван зуун) мянган төгрөг, 3 дугаар хавсралтад заасан дизель станцын үнэ 27.8 (хорин долоон сая найман зуун мянган) сая төгрөгийг 2010 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын нөөц сангаас тус тус гаргаж Онцгой байдлын ерөнхий газарт олгох;

3.2. отор нүүдэл хийж байгаа аймгуудад "Отрын штаб" байгуулан ажиллуулж, малчдад төрийн болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйл ажиллагаатай холбогдуулан гарах нэмэлт зардалд зориулан Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газарт 30.0 (гучин) сая төгрөг, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газарт 35.0 (гучин таван) сая төгрөг, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 50.0 (тавин) сая төгрөг, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газарт 30.0 (гучин) сая төгрөг, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газарт 50.0 (тавин) сая төгрөг, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 30.0 (гучин) сая төгрөг, Архангай, Баян-Өлгий, Увс, Төв, Ховд, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газарт тус бүр 15.0 (арван таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас олгох.

4. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу улсын нөөцөөс гаргаж аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд олгосон машины үнэ болох 36.0 (гучин зургаан) сая төгрөг, сумын хүн эмнэлэгт олгосон автомашины үнэ болох 119.0 (нэг зуун арван есөн сая) төгрөгийг 2010 оны



төсвийн багцаасаа тус тус гаргаж Онцгой байдлын ерөнхий газарт 2010 оны I улиралд багтаан олгохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нарт даалгасугай.

5. Өвс, тэжээл оруулах зорилгоор Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаандэл-Уул гэдэг газарт хилийн түр гарцыг нэг удаагийн арга хэмжээ болгон нээх, Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Гашуунсухайтын боомтоор өвс, тэжээл, мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох асуудлыг БНХАУ-тай тохиролцох арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

6. Төвийн бүсэд аймаг дундын отрын бэлчээр шинээр байгуулан тусгай хэрэгцээнд авах асуудлыг судалж 2009 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

7. Орон нутагт бэлтгэсэн стандарт, чанарын шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнийг батлан хамгаалах, хилийн цэрэг, нийслэлийн төсвийн байгууллагад гэрээгээр нийлүүлэх, бэлтгэсэн махыг тээвэрлэх ажлыг өвс, тэжээлийн тээвэртэй уялдуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

8. Отор нүүдлээр өөр аймгийн нутагт өвөлжиж байгаа малчид, тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг аймгийн удирдлагатай хамтран зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд төвөөс мэргэжлийн эмч нарын баг ажиллуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

9. Өөр аймаг, сумын малчин өрх, малыг отор нүүдлээр өвөлжүүлж байгаа Төв, Булган, Хэнтий аймгуудад бэлчээр усжуулах, бэлчээрийн хортон шавьж, мэрэгч амьтантай тэмцэх, бэлчээрийг нөхөн сэргээхтэй холбогдон гаргах нэмэлт зардлыг 2010 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

10. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр гарсан Засгийн газрын шийдвэр, албан даалгаврыг хангалтгүй биелүүлсэн Дундговь аймгийн Засаг дарга Ш.Төрбат, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа, Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Амарсанаа, Говь-Алтай аймгийн Засаг дарга Г.Бямбажав, Өвөрхангай аймгийн Засаг дарга Д.Тогтохсүрэн, Завхан аймгийн Засаг дарга Я.Санжмятав нарт хариуцлагаа дээшлүүлж ажиллахыг анхааруулсугай.



11. Сум, багийн харилцаа холбооны техник хэрэгслийн найдвартай ажиллагааг хангаж, цаг агаар хүндэрсэн үед холбоо барих ажлыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт үүрэг болгосугай.

12. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

12.1. нутаг дэвсгэртээ болон бусад аймаг, сумын нутагт мал отор нүүдлээр өвөлжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах;

12.2. улсын нөөцөөс гарган худалдан борлуулж байгаа малын эм, биобэлдмэл болон өвс, тэжээлийг сумдад хуваарилан малчдад ямар нэгэн дамжлагагүйгээр шууд хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

12.3. Отрын штабыг 2009 оны 12 дугаар сараас 2010 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд ажиллуулж, малчдад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийх, нийгмийн болон төрийн бусад үйлчилгээг тасралтгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авах;

12.4. ямаа, үхрийн махаар борц бэлтгэн нөөцлөх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

12.5. малчдын бэлтгэсэн махыг хадгалах, хамгаалах, гарал үүслийг тодорхойлох арга хэмжээ авч, бэлтгэсэн махны төрөл, тоо хэмжээ, чанарын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд үнэн зөв мэдээлэл өгч, дотоод, гадаад зах зээлд нэгдсэн зохион байгуулалттайгаар борлуулах чиглэлээр холбогдох яамдтай хамтран ажиллах;

12.6. мал өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хангалтгүй зохион байгуулсан, өвлийн отрыг урсгалаар нь орхигдуулсан сумдын удирдлагад хариуцлага тооцон эргэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээлэх.

13. "Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний нутгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 165 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "2009 оны 6 дугаар сарын 10-наас эхлэн 2 жилийн" гэснийг "жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 1 хүртэл" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

УЛСЫН НӨӨЦӨӨС ГАРГАЖ АЙМГУУДАД ОЛГОХ МАЛЫН ЭМ,  
БИОБЭЛДЭМЭЛИЙН ХУВААРЬ

№	Аймаг	Малын эм, биобэлдэмэлийн нэр											
		Тарга бэлдмэл		Шидэт эм		Хоромхон		Аслю-ол		Бидглюмицетин			
		Тоо СЭЖМСХ	Үнэ	Тоо СЭЖМСХ	Үнэ	Тоо СЭЖМСХ	Үнэ	Тоо СЭЖМСХ	Үнэ	Тоо СЭЖМСХ	Үнэ		
1	Архангай	47	291.870	65	538.200	27	603.504	13	93.600	9	360.000		
2	Баянхонгор	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
3	Баян-Өлгий	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
4	Говь-Алтай	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
5	Дундговь	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
6	Завхан	52	322.920	66	546.480	30	670.560	19	136.800	10	400.000		
7	Өвөрхангай	47	291.870	65	538.200	27	603.504	13	93.600	9	360.000		
8	Өмнөговь	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
9	Ховд	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
10	Хөвсгөл	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
11	Увс	47	291.870	66	546.480	27	603.504	13	93.600	9	360.000		
Дүн		522	3.241.620	724	5.994.720	300	6.705.600	149	1.072.800	100	4.000.000		
Нийт дүн												21.014.740	

Засгийн газрын 2009 оны 367 дугаар  
 тогтоолын 2 дугаар хавсралт

**УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР, ЦЭГТ НЭМЖ БАЙРШУУЛАХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН  
 ХЭМЖЭЭ БОЛОН ТҮҮНИЙГ ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Хаанаас	Хаана байршуулах	Нэр төрөл	Хэмжээ (тн)	Тээвэрлэх зай (км)	Нэг тн/км-ийн үнэ	Шаардагдах зардал (мян. төг)
1		Баянхонгор аймаг дахь улсын нөөцийн салбарт	тэжээл	250	660	210	34.650.0
2	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Баянхонгор аймгийн Бууцагаан сум дахь улсын нөөцийн салбарт		50	850	210	6.925.0
3		Баянхонгор аймгийн Баянговь сум дахь улсын нөөцийн салбарт		50	716	210	7.518.0
4		Баянхонгор аймгийн Заг сум дахь улсын нөөцийн салбарт		50	776	210	8.148.0
5	Дархан-Уул аймаг дахь улсын нөөцийн салбар	Говь-Алтай аймаг дахь улсын нөөцийн салбарт	өвс	300	1204	210	75.852.0



6	Говь-Алтай аймаг дахь улсын нөөцийн салбарт	Говь-Алтай аймаг дахь улсын нөөцийн салбарт	тэжээл	250	1067	210	56.017.5
7	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Говь-Алтай аймгийн Төгрөг сум дахь улсын нөөцийн түр цэгт	тэжээл	100	1230	210	25.830.0
8		Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум дахь улсын нөөцийн түр цэгт	тэжээл	100	900	210	18.900.0
9		Говь-Алтай аймгийн Баян-Уул сум дахь улсын нөөцийн түр цэгт	тэжээл	50	1220	210	12.810.0
10	Дорнод аймаг дахь улсын нөөцийн салбарт	Өмнөговь аймгийн төв дахь улсын нөөцийн салбарт	өвс	200	1055	210	44.310.0
11	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас		тэжээл	200	610	210	25.620.0
12	Дорнод аймаг дахь улсын нөөцийн салбарт	Өмнөговь аймгийн Номгон сум дахь нөөцийн түр цэгт	өвс	50	1156	210	12.138.0
13	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас		тэжээл	100	763	210	16.023.0
14	Дорнод аймаг дахь улсын нөөцийн салбарт	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум дахь улсын нөөцийн түр цэгт	өвс	50	976	210	10.248.0
15	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас		тэжээл	100	477	210	10.017.0



16	Дорноговь аймаг дахь улсын нөөцийн салбар	Дундговь аймгийн төв дэх улсын нөөцийн салбарт	өвс	100	356	210	7,476.0
17	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас		тэжээл	200	305	210	12,810.0
18	Дорноговь аймаг дахь улсын нөөцийн салбар		өвс	100	469	210	9,849.0
19	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Дундговь аймгийн Эрдэнэдалай сум дахь улсын нөөцийн цэгт	тэжээл	100	325	210	6,825.0
20	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Дундговь аймгийн Говь-Угтаал сум дахь улсын нөөцийн цэгт	тэжээл	100	338	210	7,098.0
21	Говьсүмбэр аймаг дахь улсын нөөцийн салбараас	Төв аймгийн төв дэх цэгт	өвс	100	212	210	4,452.0
22	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Төв аймгийн төв дэх цэгт	тэжээл	100	51	210	1,071.0
23		Төв аймгийн Бүрэн сумын Булангаа дахь улсын нөөцийн салбарт	тэжээл	200	211	210	8,862.0

24	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Өвөрхангай аймгийн Сант сум дахь улсын нөөцийн салбарт	тэжээл	200	414	210	17.388.0
25		Өвөрхангай аймгийн Нарийнгуул сум дахь улсын нөөцийн цэгт	тэжээл	200	565	210	23.730.0
26		Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь улсын нөөцийн цэгт	тэжээл	200	395	210	16.590.0
27		Завхан аймгийн төв дэх улсын нөөцийн цэгт	тэжээл	100	1076	210	22.596.0
28		Завхан аймгийн Шилүүстэй сум дахь улсын нөөцийн цэгт	тэжээл	200	1000	210	42.000.0
			өөс	900	-	-	104.325.00
			тэжээл	2.900	-	-	383.428.50
			-	3.800	-	-	547.753.50
			Бүгд				
			Нийт зардал				

**УЛСЫН НӨӨЦӨӨС АЙМГУУДАД ОЛГОЖ, НӨХӨН БҮРДҮҮЛЭХ АВТОМАШИН,  
ДИЗЕЛЬ СТАНЦЫН ХУВААРЬ**

№	Аймаг	Олгох газар	УАЗ-31512 маркийн хүн эмнэлгийн автомашин		УАЗ-396292 маркийн Фургон автомашин		АД-100 дизель станц	
			Хэмжээ	Үнэ (млн.төг)	Хэмжээ	Үнэ (млн.төг)	Хэмжээ	Үнэ (млн. Төг)
1	Дорнод	Чойбалсан дахь аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд	-	-	1	18.000.0	-	-
2	Говьсүмбэр	Малгааны талын аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд	-	-	1	18.000.0	-	-
3	Говь-Алтай	Төгрөг сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
4		Жаргалан сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
5	Завхан	Шилүүстэй сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
6		Эрдэнэхайрхан сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
7		Асгат сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
8	Өвөрхангай	Сант сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
9		Уянга сумын хүн эмнэлэгт	1	17.000.0	-	-	-	-
10		Бод суманд	1	17.000.0	-	-	-	-
Дүн			7	119.000.0	2	36.000.0	2	27.800.0



Засгийн газрын 2009 оны 367 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт

**УЛСЫН НӨӨЦИЙН ЗАРИМ САЛБАРААС ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН  
АЙМГИЙН МАЛЧДАД ХУДАЛДАН БОРЛУУЛАХ  
ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ**

№	Байршил, нэр төрөл	Хэмжих нэгж	Өвс	Тэжээл
			Хэмжээ	Хэмжээ
1	Баянхонгор аймаг	тн	527.00	809.20
	Үүнээс			
	Аймгийн төв	тн	-	345.82
	Баянговь сум	тн	108.13	254.00
	Буудцаган сум	тн	196.48	87.61
	Заг сум	тн	222.39	121.77
2	Говь-Алтай аймаг	тн	627.27	785.76
	Үүнээс			
	Аймгийн төв	тн	410.27	575.76
	Эрдэнэ сум	тн	100.00	100.00
	Баян-Уул сум	тн	97.00	100.00
	Төгрөг сум	тн	20.00	10.00
3	Дундговь аймаг	тн	541.82	329.03
	Үүнээс			
	Аймгийн төв	тн	334.82	199.03
	Эрдэнэдалай сум	тн	180.00	100.00
	Өлзийт сум	тн	-	11.54
	Говь-Угтаал сум	тн	27.00	30.00
4	Завхан аймаг	тн	820.60	667.74
	Үүнээс			
	Аймгийн төв	тн	-	100.00
	Завханмандал сум	тн	259.60	150.00
	Тосонцэнгэл сум	тн	200.00	150.00
	Тэс сум	тн	261.00	150.00
	Шилүүстэй сум	тн	100.00	117.74
5	Төв аймаг	тн	388.80	393.10
6	Өвөрхангай аймаг	тн	220.00	406.46
	Үүнээс			
	Сант сум	тн	120.00	253.46
	Нарийнтээл сум	тн	100.00	117.00
	Хархорин сум	тн	-	36.00
7	Өмнөговь аймаг	тн	240.00	673.46
	Үүнээс			
	Аймгийн төв	тн	140.00	593.46
	Мандал-Овоо сум	тн	50.00	40.00
	Номгон сум	тн	50.00	40.00
	Нийт дүн	тн	3,365.49	4,064.75

**Хаяг:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакция

Улаанбаатар-12, Төрийн орон 124 тоот

И-мэйл: turin\_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2.75

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.  
Утас 329487